

НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д. Сүхбаатарын талбай 7,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160 0035
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2024.05.13 № 03/2746
танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зарласан “Телекамерийн нэгдсэн төвийн техник, тоног төхөөрөмж, систем, программ хангамж (Улаанбаатар хот)” НЗДТГ/20240102009 дугаартай тендер шалгаруулалттай холбоотой сонирхогч этгээдээс Төрийн болон орсон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1-д заасны дагуу Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт гомдол гаргасан.

Мөн сонирхогч этгээдээс тодруулга ирүүлсэнтэй холбогдуулан тендерийн баримт бичиг /II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)/-т дараах өөрчлөлтийг оруулсан болно.

1.ТШЗ 18.1-д “Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: “Шаардахгүй” гэснийг “Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: “Шаардана”” гэж,

2. ТШЗ 18.1-д “Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: “Шаардана””

д/д	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Хүчин чадал	Тоо ширхэг
1	Ачааны машин	1 тн түүнээс дээш	1
2	Ачааны машин	5 тн түүнээс дээш	1
3	Үйлчилгээний машин		2
4	Авто кран	5 тн	2
5	Сагст өргөгч		7

гэснийг “Багц 1-д дараах Машин механизм, тоног төхөөрөмж шаардана.”

д/д	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Хүчин чадал	Тоо ширхэг
1	Ачааны машин	1 тн түүнээс дээш	1
2	Ачааны машин	5 тн түүнээс дээш	1
3	Үйлчилгээний машин		2
4	Авто кран	5 тн	2
5	Сагст өргөгч		7

“Багц 2-т дараах Машин механизм, тоног төхөөрөмж шаардана.”


д/д	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Хүчин чадал	Тоо ширхэг
1	Ачааны машин	1 тн түүнээс дээш	1
2	Үйлчилгээний машин		1

3.ТШЗ 20.1-д “Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн суурилуулалтыг хийж, бүрэн ажиллагаанд оруулан захиалагч талд хүлээлгэн өгсөн талаар гэрээ, хүлээлгэж өгсөн акт, захиалагчийн тодорхойлолт болон НӨАТ-ын баримт хавсарган ирүүлнэ.” гэснийг “Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн суурилуулалтыг хийж, бүрэн ажиллагаанд оруулан захиалагч талд хүлээлгэн өгсөн талаар гэрээ, хүлээлгэж өгсөн акт, захиалагчийн тодорхойлолт, хийж, гүйцэтгэсэн ижил, төстэй ажлыг шалгах зорилгоор захиалагч байгууллагаас тодруулга, лавлагаа, мэдээлэл авахад татгалзах зүйлгүй гэсэн мэдэгдэл ирүүлнэ.” гэж,

4.ТШЗ 26.1-д “Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр, Цаг: 11 цаг 00 минут” гэснийг “Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр, Цаг: 11 цаг 00 минут” гэж,

5.ТШЗ 26.2-т “Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр, Цаг: 11 цаг 15 минут” гэснийг “Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр, Цаг: 11 цаг 15 минут” гэж тус тус өөрчлөв.

ДАРГА



Л.ХОСБАЯР